



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЗӨВЛӨМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйл, “Төрийн жинхэнэ албан хаагчийг оор албаал тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх хүрээнд зөвлөмжийг өгч байна.

1. Төрийн албаны тухай хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан төрийн жинхэнэ албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 44.1 дох хосоогт зааснаар “шилжүүлэн томилж” албан тушаалын оул орон тоог нохиж болно.

2. Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “...удирдлагын хооронд харилцан тохиролцсон” гэдэгт төрийн жинхэнэ албан хаагчийн зөвшөөрлийг үндэслэн шилжүүлэн авах тухай хүсэлтэд шилжүүлж буй байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийг ойлгоно. Зөвшөөрсөн бичигт төрийн албан хаагчийн эцэг, эхийн болон өөрийн нэр, тухайн албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах зайлшгүй шаардлага, хугацаа, албан тушаалыг дурдсан байна.

3. Төрийн жинхэнэ албан хаагчийг байгууллага, байгууллагын нэгж хооронд албан тушаалд шилжүүлэх, шилжүүлэн авч ажиллуулах шийдвэрийг Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт зааснаар томилох эрх бүхий албан тушаалтан гаргана.

Албан хаагчийг байгууллага хооронд шилжүүлж байгаа тохиолдолд томилсон шийдвэр гаргасан өдөрт багтааж шилжүүлэн авч байгаа байгууллага шийдвэр гаргана.

4. “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол журам”-ын 1.3.1¹-т зааснаас бусад тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн ангиллын албан тушаалд албан хаагчийн боловсрол, туршлага, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлага, ур чадварын байдлыг харгалzan албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангаж буй тохиолдолд адил төрлийн² албан тушаалын адил ангилалд³ шилжүүлэн ажиллуулж болно.

¹ Төрийн захиргааны албаны тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах төсвийн шууд захирагч, яамны газрын дарга, агентлагийн дэд дарга

² ТАТХ-ын 10 дугаар зүйлийн 10.2-т “Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрелтэй байна.” гэж зааснаар ойлгоно.

³ ТАТХ-ын 18 дугаар зүйлийн 18.1-т “Төрийн захиргааны албан тушаалыг доор дурдсанаар ангилна: 18.1.1.тэргүүн түшмэл; 18.1.2.эрхэлсэн түшмэл; 18.1.3.ахлах түшмэл; 18.1.4.дэс түшмэл; 18.1.5туслах түшмэл;

5. Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийг адил ангилал, зэрэглэлийн төсвийн шууд захирагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангаж, сонгон шалгаруулалтын дагуу томилогдсон тохиолдолд шилжүүлэх, сэлгэн ажиллуулж болно. (Тухайлбал: Т3-15-аас Т3-15, Т3-14-өөс Т3-14, Т3-11-ээс Т3-11, Т3-9-өөс Т3-9 гэх мэт.)

6. Сэлгэн ажиллуулах гэдэгт албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээг бууруулахгүйгээр адил төрлийн албан тушаалын ангилал дотор өөр албан тушаалд хууль, журамд заасан хугацаагаар хоёр албан хаагчийг хооронд нь сэлгэн томилохыг ойлгоно.

7. Төрийн жинхэнэ албан хаагчийг албан ажлын зайлшгүй шаардлагаар Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт заасны дагуу нэг байгууллагаас нөгөө байгууллагад сэлгэн ажиллуулж болно. Энэ тохиолдолд албан хаагчтай гэрээ байгуулах бөгөөд албан тушаалын орон тоог хадгална.

8. Байгууллага дотор нэгжийн өөр албан тушаалд сэлгэн ажиллуулахад "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 3.5-д зааснаар гэрээ байгуулна.

9. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн, удирдлага солигдсон нь сэлгэн ажиллуулах шийдвэрийг хугацаанаас өмнө цуцлах үндэслэл болохгүй.

Сэлгэн ажиллуулсан албан хаагчийг үндсэн орон тоонд үргэлжлүүлэн ажиллуулах тохиолдолд гэрээний хугацааг дуусгавар болгон тухайн албан тушаалд томилно.

10. Сэлгэн ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагч тусгай шалгалтын үр дүнгээр албан тушаалд томилогдсон тохиолдолд гэрээний хугацаа дуусгавар болно.

11. Төрийн албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах шаардлага, ажлын байрны мэдээллийг журмын дагуу "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгүүлсэн байна.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ